



**ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД ОЛГОСОН
ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН МЭДЭЭЛЭЛ**



НИЙТ ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

358.5

ТЭРБУМ ИЕН

182.4

ТЭРБУМ ИЕН

**ХӨНГӨЛӨЛТТЭЙ
ЗЭЭЛ**

120.4

ТЭРБУМ ИЕН

**БУЦАЛТГҮЙ
ТУСЛАМЖ**

55.7

ТЭРБУМ ИЕН

**ТЕХНИКИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГАА**



ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХҮРЭЭНД:



Олон улсын нисэх онгоцны шинэ буудал (2009-2021)



**Инженерийн дээд боловсролыг хөгжүүлэх төсөл
/2014-2023/**



**Төсөв, нийгэм, эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн
бодлогын зээл /2017-2020/**



Экспортын зээлийн шугам нээх тухай төсөл



**“КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний
яаралтай тусламжийн зээл (2020-2021)**



Олон улсын нисэх онгоцны шинэ буудал (2009-2021) **энд дар**

Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл"-ийг санхүүжүүлэх **28.8 тэрбум иений Зээлийн гэрээг** 2008 оны 05 дугаар сарын 01-ний өдөр, **36.8 тэрбум иений Нэмэлт зээлийн хэлэлцээрийг** 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр байгуулж, УИХ-аар 2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр болон 2015 оны 6 дугаар сарын 5-ны өдөр тус тус соёрхон баталсан.

Засгийн газрын шийдвэрээр зээлийн хөрөнгөнөөс хэмнэгдсэн эх үүсвэрээр Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын ажлыг 2018 оны 6 дугаар сараас 2019 оны 12 дугаар сард гүйцэтгэн **Улсын комисс барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.**



Шинэ нисэх онгоцны буудлын хүчин чадал **3 дахин нэмэгдэж 6 терминалтай, жилд 22 мянга удаагийн онгоц хөөргөх болон буулгах хүчин чадалтай, 3 сая зорчигч хүлээн авна.** Шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орсноор иргэний болон агаарын тээврийн аюулгүй байдал нэмэгдэн, нийгэм, эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэнэ. Зээлийн нийт ашиглалт 99 хувьтай байна.

Инженерийн дээд боловсролыг

хөгжүүлэх төсөл /2014-2023/ энд дар

Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд **7.5 тэрбум иений** Инженерийн дээд боловсролыг хөгжүүлэх төсөл-ийн зээлийн гэрээг 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулж, УИХ-аар мөн оны 5 дугаар сарын 3-ны өдөр соёрхон баталсан.

Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, инженерийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчныг шинэчлэх, чанарыг сайжруулах зорилго бүхий уг төсөл нь **2014 оноос амжилттай хэрэгжиж байна. Өнөөгийн байдлаар төслийн хүрээнд:**

* Япон Улсад инженер, технологийн чиглэлээр өндөр мэдлэг ур чадвар бүхий 683 оюутан, багш, судлаачид суралцаад байна

* “Коосэн хөтөлбөр”-ийн оюутнууд Монгол Улсын тэргүүлэх компаниудад ажлын гараагаа эхлүүлээд байна.

* “Хамтарсан судалгаа”-ны багуудаас гадаадад 147, дотоодод 124 эрдэм шинжилгээний өгүүлэл, 300 гаруй хураангуй илтгэл хэвлүүлэв.

* Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн сургалт судалгааны 33 лабораторид 131 нэр төрлийн 1469 ширхэг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нийлүүлэгдсэн байна



Төсөл амжилттай хэрэгжсэнээр өндөр мэдлэг, практик чадвар бүхий инженер мэргэжилтнүүд бэлтгэгдэн, **МУИС, ШУТИС-ийн инженер бэлтгэх сургалтын хөтөлбөр олон улсын жишигт хүрч**, багш нарын мэргэжил арга зүй сайжирч, сургалтын чанар дээшлэн сургалтын материаллаг бааз бүрдэж, судалгааны ажлын чанар болон судалгааны лаборатори, тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжирч, олон улсын хамтарсан судалгаа хийгдэн бодит үр дүнг практикт нэвтрүүлнэ гэж үзэж байна.



Төсөв, нийгэм, эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээл /2017-2020/ энд дар

Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд “Төсөв, нийгэм болон эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээл”-ийн Санхүүжилтийн **хэлэлцээрийг 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдөр байгуулж, 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдөр УИХ-аар соёрхон баталсан.**

Япон Улсын Засгийн газар нь Монгол Улсын төсөв, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, төсвийн дэмжлэг олгож ирсэн бөгөөд энэхүү санхүүжилт нь 5 дахь удаагийн төсвийн дэмжлэг болно. Энэхүү бодлогын зээл нь Макро эдийн засгийн тогтвортой удирдлагаар хангах, нийгмийн эмзэг бүлэгт туслалцаа үзүүлэх болон эдийн засгийг тогтворжуулах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын арга хэмжээг хэрэгжүүлснээр **Монгол Улсын төсвийн зардлыг санхүүжүүлэв.**



Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай хамтран хэрэгжүүлэх “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн санхүүжилтийн багцын хүрээнд Япон Улсын Засгийн газраас төсвийн дэмжлэг болгож **850 сая ам.доллартай тэнцэх хэмжээний иений зээлийг 3 жилийн хугацаанд олгохоор амласан.**



Экспортын зээлийн шугам нээх тухай

төсөл энд дар

Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны банк (ЯОУХАБанк) хооронд Япон Улсын орчин үеийн техник технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх замаар үндэсний үйлдвэрлэл, хувийн хэвшлийг дэмжих зорилго бүхий “Экспортын зээлийн шугам нээх тухай төсөл”-ийн зээлийн Ерөнхий хэлэлцээрийг 2013 оны 6 дугаар сарын 06-ны өдөр байгуулж, **2013 оны 7 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан.**

Төслийн хүрээнд нийт 8.0 тэрбум иенээс хэтрэхгүй хэмжээний зээлийн хөрөнгийг төсөлд оролцогч 7 банкаар дамжуулан Тусгайлсан зээлийн хэлэлцээрийн хүрээнд дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудад дамжуулан зээлдүүлж, аж ахуйн нэгжийн санал болгосон төсөлд олгох санхүүжилтийн **доод хэмжээ 10.0 сая иен, эсвэл 1.0 сая ам.доллар байна.** Төсөлд Төрийн банк, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк (ХХБ), Голомт банк, Хас банк, Улаанбаатар хотын банк болон Монгол Улсын Хөгжлийн банкнууд оролцогч санхүүгийн байгууллагаар сонгогдсон бөгөөд Сангийн яам Дамжуулан зээлдүүлэх гэрээг 2014 оны 7 дугаар сард эдгээр банкнуудтай байгуулсан.



Тусгайлан зээлийн хэлэлцээрийн хүрээнд нийт **1.9 тэрбум иений** ашиглалт гарсан. Зээлийн хөрөнгөөр **уул, уурхайн машин, тоног төхөөрөмж, хэвлэх машин, ухаалаг АТМ машин худалдан авах үйл ажиллагааг санхүүжүүлсэн.**

“Экспортын зээлийн шугам нээх” төслийн зээлийн санхүүжилтээр “Багануур” ХК болон “Шивээ овоо” ХК-ий үйлдвэрлэлийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх технологийн шинэчлэл хийх төслийн **1.3 тэрбум иен буюу 37.5 тэрбум төгрөгийн “Тусгайлсан зээлийн хэлэлцээр 5”-т** Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Японы Олон улсын хамтын ажиллагааны банкны Дэд бүтэц, хүрээлэн буй орчны санхүүжилтийн бүлгийн дарга, гүйцэтгэх захирал М.Танимото нар 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр гарын үсэг зурсан.

“КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний яаралтай тусламжийн зээл (2020-2021) энд дар

Япон Улсын Засгийн газраас Монгол Улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед Засгийн газраас авч хэрэгжүүлж буй эдийн засгийг эрчимжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих, нийгэм, эдийн засаг үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан эдийн засгийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор яаралтай тусламжийн **зээлийг төсвийн дэмжлэг хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн.**

Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулах “КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний яаралтай тусламжийн зээл”-ийн Зээлийн хэлэлцээрт 2020 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр байгуулж, УИХ-аар 12 дугаар сарын 3-ны өдөр соёрхон баталсан. Зээлийн санхүүжилтийн **нийт дүн 25.0 тэрбум иен, эргэн төлөх хугацаа 15 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 4 жил, зээлийн хүү жилийн 0.01%, урьдчилгаа шимтгэл 0.1%** байна.



Зээлийн эхний санхүүжилт **687.1 тэрбум төгрөг буюу 241.3 сая ам доллар 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Төрийн сангийн дансанд орж ирсэн.**



БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭНД:



Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр



Монгол-Японы сургалтын эмнэлэг



Улаанбаатар хотын бага, дунд боловсролын барилга байгууламжийг сайжруулах төсөл (2017-2020)

Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр энд дар

Япон Улсын Засгийн газрын Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөрт **2001 оноос Монгол Улс хамрагдан өнөөгийн байдлаар нийт 20 төсөл хэрэгжиж**, 360 оюутан Японы их дээд сургуулиудад суралцан, санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, уур уурхай, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил, боловсрол, ур чадвараа дээшлүүлэн, эх орондоо буцан ирж төрийн байгууллагуудад үр бүтээлтэй ажиллаж байна.

Маанай талаас Япон Улсын Элчин сайдын яаманд “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 2020-2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хүсэлтийг 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдөр хүргүүлсний дагуу Япон Улсын Засгийн газраас 2020 оны санхүүгийн жилд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж **249.0 /хоёр зуун дөчин есөн/ сая иений буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэн** талууд энэ 6 дугаар сарын 17-ны өдөр Засгийн газар хооронд солилцох ноот бичигт гарын үсэг зурсан. Хөтөлбөрийн хүрээнд 18 төрийн болон хувийн хэвшлийн албан хаагчдыг магистр, докторын сургалтад хамруулна.



JDS | The Project for Human Resource Development Scholarship by Japanese Grant Aid **2019**
Япон улсад тэтгэлгээр Магистр, Докторт сурцгаа.

СУРАЛЦАХ ЧИГЛЭЛЭҮҮД:

Ашигт малтмал, Эдийн засаг, Хууль эрхзүй, Бизнесийн удирдлага, Олон нийтийн бодлого зохицуулалт, Инженер, Байгаль орчин

МАГИСТРЫН ТҮВШНИЙ ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШАЛГУУР:

НАС:
БОЛОВСРОЛ:

АНГЛИ ХЭЛ ДЭЭР ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ЭЛСЭГЧДИЙН АЖЛЫН ТҮРШЛАГА:
ЯПОН ХЭЛ ДЭЭР ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ЭЛСЭГЧДИЙН АЖЛЫН ТҮРШЛАГА:

2020 оны 4-р сарын 1-ний байдлаар 25-аас 39 настай байх Монгол улсын болон гадаад орны магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд бакалаврын зэрэг хамгаалсан байх Монгол улсын төрийн төв, орон нутгийн байгууллагад 2-оос дээш жил үндсэн албан хаагчаар ажилласан байх (Төрийн өмчит компаниуд болон төрийн улс төрийн албан хаагчид хамрагдах боломжгүй)

Хувийн хэвшлийн компани / байгууллага эсвэл төрийн өмчит компанид үндсэн ажилтнаар доод тал нь 2 жил ажилласан байх

ДОКТОРЫН ТҮВШНИЙ ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШАЛГУУР:

НАС:

БОЛОВСРОЛ:
АЖЛЫН ТҮРШЛАГА:

2020 оны 4-р сарын 1-ний байдлаар 45 ба түүнээс доош настай байх Японд магистрын зэрэг хамгаалсан байх Магистраа төгсөж ирээд 2-оос доошгүй жил Монгол улсын төрийн төв, орон нутгийн байгууллагад үндсэн албан хаагчаар ажилласан байх





Монгол-Японы сургалтын эмнэлэг энд дар

Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд “Монгол-Японы сургалтын эмнэлэг барих” төслийг хэрэгжүүлэх **141.0 сая иений буцалтгүй тусламжийн** гэрээг 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, **7.9 тэрбум иений нэмэлт буцалтгүй тусламжийн** гэрээг 2015 оны 3 дугаар сарын 12-ны өдөр тус тус байгуулсан. Энэ хүрээнд Монгол-Японы сургалтын эмнэлэг барих төсөл **нийт 8.1 тэрбум иений буцалтгүй тусламжийн** санхүүжилтээр 2016 оны 4 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн.

Засгийн газрын 2013 оны 346 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн эмнэлэг байгуулах ажлыг Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулах, 2019 оны 53 дугаар тогтоолоор Нийслэлийн Баянзүрх дүүргийн хүн амд үндсэн мэргэшлээр, улсын хэмжээнд зарим төрөлжсөн мэргэшлээр тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлэг” байгуулахаар шийдвэрлэн **Монгол-Японы сургалтын эмнэлгийн үйл ажиллагааг 2019 оны 6 дугаар сард нээсэн.**



Монгол-Японы сургалтын эмнэлэг нь амбулатори, дүрс оношилгоо, дуран, яаралтай түргэн тусламж, эрчимт эмчилгээ, мэс засал, лаборатори, эмийн сан, ариутгал, гал тогоо, захиргаа, сургалт, эмийн үзлэгийн картын архив, цогцос хадгалах өрөө, ерөнхий үйлчилгээний хэсэг зэрэг **15,730 м2 талбай бүхий 3 давхар, нийт 250 ор бүхий хүчин чадлаар жилд хэвтэн эмчлүүлэх тасагт 4,300 орчим, амбулаториор 600 орчим мянган хүнд** эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой.



Улаанбаатар хотын бага, дунд боловсролын барилга байгууламжийг сайжруулах төсөл (2017-2020) энд дар

Төслийн хүрээнд хүүхдүүдийг тэгш хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг суралцах боломжийг бүрдүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, байгаль орчинд ээлтэй, сургалтын аюулгүй байдлыг хангасан **нийт 2196 суудал бүхий загвар 4 сургуулийг** Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Налайх дүүргүүдэд барьж энэ онд ашиглалтад оруулсан. Үүнд:

- **Хан-Уул дүүргийн 75 дугаар сургууль:** Нийт 828 суудал бүхий 23 ангитай, компьютерын өрөө, номын сан, хөдөлмөрийн ангиуд, лекцийн танхим, биеийн тамирын заал, цайны газар, цахилгаан үүсгүүр бүхий 6,317 м² талбайтай;
- **Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны сургууль:** Нийт 648 суудал бүхий 18 ангитай, компьютерын өрөө, номын сан, хөдөлмөрийн ангиуд, лекцийн танхим, биеийн тамирын заал, цайны газар, уурын зуух бүхий 5,060 м² талбайтай;
- **Баянзүрх дүүргийн 53 дугаар сургуулийг өргөт гөх:** Нийт 432 суудал бүхий 12 ангитай, компьютерын өрөө, номын сан, жижиг биеийн тамирын заал, буфет, цахилгаан үүсгүүр бүхий 3,346 м² талбайтай;
- **Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийг өргөт гөх:** Нийт 288 суудал бүхий 8 ангитай, компьютерын өрөө, номын сан, хөдөлмөрийн ангиуд, буфет, цахилгаан үүсгүүр болон уурын зуух бүхий 2,649 м² талбайтай



Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “Улаанбаатар хотын бага, дунд боловсролын барилга байгууламжийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэхээр **2.4 тэрбум иений буцалтгүй тусламжийн гэрээг байгуулсан.**



ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын засгийн газар, Япон Улсын засгийн газар хооронд техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг **2003 оны 12 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан.**

Техникийн хамтын ажиллагаа нь Японы Засгийн газрын ХАЁТ-аар хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын мэргэжилтнүүд Монголд ирж ажиллах, Монголоос Японд сургалтад хамруулах, туршлага судлах дадлага хийх, техник тоног төхөөрөмжийн нийлүүлэлт гэсэн 3 үндсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгдэг. Өнөөгийн байдлаар хамтран ажиллах тэргүүлэх чиглэлийн хүрээнд **нийт 24 төсөл, 2 хөгжлийн бодлогын судалгаа, урт болон богино хугацааны сургалт, зөвлөх үйлчилгээ хэрэгжиж байна.**

